



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/08

Зуунмод

Аймгийн начин цол нөхөн
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Эрдэнэсант сумын харьяат Чогсомжавын Дарамбазрын 1987 оны Төв аймгийн 64 ойн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд амжилттай барилдаж тав давсан амжилтыг үнэлж АЙМГИЙН НАЧИН цол нөхөн олгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР

